

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: **2025.02.03**

№ **25/13**

Улаанбаатар хот

Богд банкны хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам батлах, худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 53, 54, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.7 дахь хэсэг, Богд банкны дүрмийн 6 дугаар зүйл, Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/01 тоот шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Богд банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/01 тоот шийдвэрээр тус банкныг хаалттай хувьцаат компани болгохоор шийдвэрлэсэн тул бусад хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг энэхүү тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.
2. Нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг 150 /нэг зуун тавь/ төгрөг байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид 2025 оны 02-р сарын 05-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
4. Хувьцаа буцаан худалдан авах тухай мэдэгдэл буюу зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу 2025 оны 02-р сарын 07-ны болон 02-р сарын 22-ны өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсүгэй.
5. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах зарын загварыг энэхүү тогтоолын Хавсралт №2-р баталсугай.
6. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах хугацааг олон нийтэд анх мэдэгдсэнээс хойш ажлын 30 өдөр буюу 2025 оны 02-р сарын 07-ны өдрөөс 2025 оны 03-р дугаар сарын 21-ний өдрийг дуустал байхаар тогтоосугай.
7. Банкны тухай хуулийн 28-р зүйлийн 28.1, 28.4 дэх заалтад заасны дагуу Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг олгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор тогтоолын 6-д заасан хувьцаа эзэмшигчдийн хувьцааны төлбөрийг шилжүүлсүгэй.
8. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг "Апекс капитал ҮЦК" ХХК-д бичгээр болон цахим хэлбэрээр хүлээн авахаар тогтоосугай.
9. Энэхүү тогтоолыг болон хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
№25/13 тоот тогтоолын Хавсралт №1



**"БОГД БАНК" ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэхүү журмаар "Богд банк" хаалттай хувьцаат компани (*цаашид "Банк" гэх*)-иас өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх, Банк тогтоосон хугацаанд шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцааг зарласан үнээр эргүүлэн худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн №25/13 тоот тогтоолоор энэхүү журмын 1.1-д заасны дагуу шаардлага гаргах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг 2025 оны 02-р сарын 03-ны өдрөөр тогтоосон бөгөөд нэгж хувьцааны үнийг 150 /нэг зуун тавь/ төгрөгөөр тогтоосон.
- 1.3 Банк нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/01 тоот шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн №25/13 тоот тогтоолын 3-т заасны дагуу энэхүү журмыг хэрэгжүүлж байгаа болно.


ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/01 тоот шийдвэр, Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн №25/13 тоот тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхтэй.
- 2.2. 2.1-д заасан банкны хувьцаа эзэмшигч нь 2025 оны 02-р сарын 07-ны өдрөөс эхлэн мөн оны 03-р сарын 21-ний өдрийн оройн 17 цаг хүртэлх хугацаанд өөрийн шаардлагаа цахим болон цаасан хэлбэрээр "Апекс капитал ҮЦК" ХХК-д ирүүлнэ.
- 2.3. Хувьцаа эзэмшигч нь 2.2-т заасан шаардлагыг гаргахдаа эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар эсвэл иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй хувьцааны тоо, төрөл, холбогдох утасны дугаарыг бүрэн, үнэн зөв тусгасан байна.
- 2.4. Хувьцаа эзэмшигч нь шаардлагаа өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан бүрдүүлбэрийн хамт "Апекс капитал ҮЦК" ХХК-д илгээж болно.

ГУРАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Банк нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхийг хэрэгжүүлэх мэдэгдэл буюу зарыг 2025 оны 02-р сарын 07-ны өдөр болон мөн оны 02-р сарын 22-ны өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж хүргэнэ.
- 3.2. Банк зарыг өдөр тутмын сонин хэвлэлээр дамжуулж хүргэх үед 3.1-д заасан хугацаа нь амралтын өдөр байх тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр зарыг сонинд нийтлүүлнэ.

**ДӨРӨВ. ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ
АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**



4.1. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь энэ тухай шаардлагаа энэхүү журмын хавсралт №1-д заасан маягтын дагуу бичгээр гаргах бөгөөд доорх хаяг руу цаасан хэлбэрээр биечлэн эсвэл цахим хэлбэрээр хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигч нь өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулж доорх хаягт хүсэлтээ илгээж болно.

№	Шаардлага хүлээн авах компанийн нэр	Цаасан хэлбэрээр хүргүүлэх хаяг	Цахим хэлбэрээр хүргүүлэх хаяг
1	“Апекс капитал ҮЦК” ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж, Нью Хоризонс оффис, 9-р давхар, 901 тоот	investment@apex.mn

- 4.2. Хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.2-д заасан хугацаанд багтаан шаардлагаа ирүүлээгүй тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтайд тооцож бөгөөд шаардлага гаргахтай холбоотой асуудлаар аливаа гомдол гаргах эрхгүй байна. Энэ тохиолдолд банк хариуцлага хүлээхгүй.
- 4.3. Банк болон “Апекс капитал ҮЦК” ХХК нь хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн шаардлага нь шаардлага хангасан эсэхийг шалгана.
- 4.4. Хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авах хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш эзэмшигчийн хүсэлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлж ТУЗ-н тогтоолын 7-д заасан хугацаанд гүйлгээг хийнэ.
- 4.5. Журамд заасан шаардлагыг хангасан хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг банк ТУЗ-ийн №25/13 тоот тогтоолын 2-т заасан үнээр тооцож Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулна.
- 4.6. Хувьцаа эзэмшигч нь энэ журамд заасны дагуу шаардлагаа хэрэгжүүлж, хувьцааг эргүүлэн худалдсан тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдна.

Хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах
эрхийг хэрэгжүүлэх журмын Хавсралт №1

**ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ БАНКНААС
ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ**



/Иргэн/

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/13 тоот тогтоолын дагуу тус банк дахь өөрийн эзэмшлийн ширхэг энгийн хувьцааг нийт төгрөгөөр /нэгж хувьцааны үнэ: 150 төгрөг/ банкинд буцаан худалдах хүсэлт буюу шаардлагыг гаргаж байна.

1. Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
2. Иргэний бүртгэлийн эсвэл регистрийн дугаар:
3. Оршин суугаа хаяг:
4. Холбоо барих утас:
5. И-мэйл хаяг:
6. Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар:
7. Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо, ширхэг.
8. Гарын үсэг:
9. Хүсэлт гаргасан огноо:
10. Иргэний цахим үнэмлэхний хуулбар эсвэл и-монголиа системээс гарсан лавлагааг хавсаргав.



Хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын Хавсралт №2

ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ БАНКНААС ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ

/Хуулийн этгээд/

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/13 тоот тогтоолын дагуу тус банк дахь өөрийн эзэмшлийн ширхэг энгийн хувьцааг нийт төгрөгөөр /нэгж хувьцааны үнэ: 150 төгрөг/ банкинд буцаан худалдах хүсэлт буюу шаардлагыг гаргаж байна.

1. Хуулийн этгээдийн нэр:
2. Улсын бүртгэлийн дугаар:
3. Регистрийн дугаар:
4. Хуулийн этгээдийн хаяг:
5. Холбоо барих утас:
6. И-мэйл хаяг:
7. Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар:
8. Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо, ширхэг.
9. Гүйцэтгэх захирал: /тамга/
10. Хүсэлт гаргасан огноо:
11. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.



Төлөөлөн удирдах зөвлөлийн
№25/13 тоот тогтоолын Хавсралт №2

**"БОГД БАНК" ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Богд банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/01 тоот шийдвэрээр банкнийг хаалттай хувьцаат компани болгохоор шийдвэрлэсэн тул банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №25/13 тоот тогтоолоор хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг банкнаас шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан тул хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг банкнаас шаардах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг банкнаас шаардах шаардлагын тухайд

Богд банкны ТУЗ-өөс хувьцаагаа эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнийг 150 /нэг зуун тавь/ төгрөгөөр тогтоож, банкны хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч холбогдох шаардлагыг гаргах эрхтэй байхаар тогтоосон.

Хувьцаагаа эргүүлэн худалдах авахыг банкаас шаардах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь нэгж хувьцаагаа 150 төгрөгөөр тооцож банкинд эргүүлэн худалдах бол дараах хүсэлтийг 2025 оны 03-р сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд багтаан "Апекс капитал ҮЦК" ХХК-д дараах бүрдүүлбэрийн хамт хүсэлтээ гаргана уу.

Хувьцаа эзэмшигч нь өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан шаардлагыг бүрдүүлбэрийн хамт "Апекс капитал ҮЦК" ХХК-д илгээж болно.

Бүрдүүлэх бичиг баримт:

Хувьцаа эзэмшигч нь иргэн бол:

1. Журмын хавсралтаар батлагдсан хүсэлтийг ирүүлэх;
2. Хувьцаа эзэмшигч нь иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, эсвэл и-монголиа-с авсан лавлагаа;

Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
2. Гүйцэтгэх захирлаас өөр этгээд төлөөлөх тохиолдолд эрх олгосон итгэмжлэл;
3. Журмын хавсралтаар батлагдсан хүсэлтийг ирүүлэх;

Хүсэлт хүлээн авах:

№	Шаардлага хүлээн авах компанийн нэр	Цаасан хэлбэрээр хүргүүлэх хаяг	Цахим хэлбэрээр хүргүүлэх хаяг
1	"Апекс капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Нью Хоризонс оффис, 9-р давхар, 901 тоот	investment@apex.mn

Холбоо барих утас: 7510-7500, 8001-9595